

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн судалгааны дүн

ҮСХ, СЗХ-ноос хамтран үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг улс даяар 2020 оны 4 сарын 1-нээс 4 сарын 10-ны хооронд зохион байгуулж, судалгааны хураангуйлсан дүнг гаргалаа.

Судалгаанд хамрагдсан нэгж. Судалгаанд нийт 1155 иргэн, аж ахуйн нэгж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхэлж байна. Дээрх үйл ажиллагааг эрхлэгчдийн 1034 (89.4%) нь иргэн, 121 (10.5%) нь аж ахуйн нэгж байна. Эндээс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжааг голлон иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид явуулж байна гэсэн үр дүнтэй байна.

Хүснэгт 1. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо

	Бүгд	Иргэн	Аж ахуйн нэгж
Нийт дүн	1155	1034	121

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгчдийн 557 буюу 48.1 хувь нь Улаанбаатар хотод, 600 буюу 51.9 хувь нь аймгуудад үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Бүгд	ААН	Иргэн
Архангай	5	-	5
Баян-Өлгий	18	1	17
Баянхонгор	40	4	36
Булган	10	2	8
Говь-Алтай	36	2	34
Говьсүмбэр	3	1	2
Дорноговь	23	4	19
Дорнод	10	-	10
Дундговь	24	1	23
Завхан	66	12	54
Өвөрхангай	84	2	82
Өмнөговь	47	2	45
Сүхбаатар	26	4	22
Сэлэнгэ	24	1	23
Төв	12	-	12
Увс	20	4	16
Ховд	13	3	10
Хөвсгөл	32	4	28
Хэнтий	21	-	21
Дархан-Уул	33	-	33
Орхон	51	4	47
Улаанбаатар	557	71	486
Дүн	1155	121	1034

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгчдийн 317 буюу 56.9% нь үйл ажиллагаагаа явуулж байгаа бол Баянгол дүүрэгт 75 буюу 13.5% Сүхбаатар дүүрэгт 57 буюу 10.2 хувь байна.

Хүснэгт 3. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо, нийслэлд

Дүүрэг	Бүгд	ААН	Иргэн
Багануур	7	1	6
Баянгол	75	6	69
Баянзүрх	54	7	47
Налайх	5	1	4
Сонгино хайрхан	18	2	16
Сүхбаатар	57	25	32
Хан-Уул	24	8	16
Чингэлтэй	317	21	296
Дүн	557	71	486

Судалгаанд хамрагдсан нэгж, үйл ажиллагааны төрлөөр.

Судалгааны урьдчилсан дүнгээр үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 454 (**39.3%**) үнэт металл эдлэлийн худалдааг, **299 (25.9%)** нь үйлдвэрлэгч буюу алт, мөнгөний дарханы үйл ажиллагааг эрхэлж байна. Эдгээр үйл ажиллагаа эрхлэгчид нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 65.1 хувийг (753) буюу дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо, үйл ажиллагааны төрлөөр

Үйл ажиллагааны төрөл	Бүгд	Дангаараа эрхэлдэг	Холимог эрхэлдэг
Үнэт чулууны худалдаа	33	11	22
Хагас үнэт чулуу худалдаа	16	5	11
Гоёл чимэглэлийн чулуу худалдаа	35	12	23
Үнэт металл эдлэлийн худалдаа	454	324	130
Үнэт чулуун эдлэлийн худалдаа	36	18	18
Хагас үнэт чулуун эдлэлийн худалдаа	35	24	11
Гоёл чимэглэлийн чулуун эдлэлийн худалдаа	56	49	7
Эртний эдлэлийн худалдаа	33	32	1
Олборлогч	5	-	5
Үйлдвэрлэгч (алт, мөнгөний дархан гэх мэт)	298	290	8
Дундын зуучлагч	99	98	1
Өнгөлөгч	2	-	2
Дахин борлуулагч	14	14	-
Бусад	39	39	-
Дүн	1155	917	239

Судалгаанд хамрагдсан нэгжийн бүтээгдэхүүний гарал, үүсэл. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчид өөрсдийн худалдаалдаг бүтээгдэхүүнийхээ гарал үүслийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Зураг 2. Бүтээгдэхүүний гарал, үүсэл дүнд эзлэх хувиар



Үүнд, 480 (41.6%) нь иргэнээс бэлэн бүтээгдэхүүн авдаг, 237 (20.5%) нь импортоор авдаг, 198 (17.1%) нь аж ахуйн нэгжээс бэлэн бүтээгдэхүүн авдаг, 171 (14.8%) дотооддоо үйлдвэрлэх замаар бэлтгэж, худалдаалдаг үр дүн гарчээ. Эдгээр нь нийт дүнгийн дийлэнх буюу 94.0 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо, бүтээгдэхүүний гарал, үүсэл

	Бүгд	Дангаараа	Холимог
Импортоор авдаг	237	133	104
Дотооддоо үйлдвэрлэдэг	171	128	43
Аж ахуйн нэгжээс бэлэн бүтээгдэхүүн авдаг	198	104	94
Иргэнээс бэлэн бүтээгдэхүүн авдаг	480	466	14
Өнгөлөгч, дархадаас бэлэн бүтээгдэхүүн авдаг	14	14	-
Бусад	55	55	-
Дүн	1155	900	255

Судалгаанд хамрагдсан нэгжийн бүтээгдэхүүний гол түүхий эд.

Эдгээр худалдаа, арилжаа эрхлэгчдээс бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн гол түүхий эдийн талаарх мэдээллийг авахад 914(78.9%) үнэт металл (алт, мөнгө, плантина), 102 (8.8%) нь гоёл чимэглэлийн чулуу (хаш, шүр, хув, усан болор г.м)-г бүтээгдэхүүнийхээ түүхий эдээр ашигладаг гэсэн хариулт өгчээ.

Зураг 3. Бүтээгдэхүүний гол түүхий эд, дүнд эзлэх хувиар



Хүснэгт 5. Бүтээгдэхүүний гол түүхий эдийн талаарх мэдээлэл


Үзүүлэлт	Дүн	Дүнд эзлэх хувь
Үнэт металл (алт, мөнгө, плантина)	913	78.9
Үнэт чулуу (доржпалам, бадмаараг, индраанил, сувд г.м)	32	2.8
Хагас үнэт чулуу (сапфир, молор, ягаан болор г.м)	40	3.5
Гоёл чимэглэлийн чулуу (хаш, шүр, хув, усан болор г.м)	102	8.8
Өнгөлгөөний чулуу (хас, боржин гантиг, баргилт г.м)	34	2.9
Бусад	34	2.9
Бүгд	1155	100.0

Судалгаанд хамрагдсан нэгжийн бүтээгдэхүүний үнэ. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдаа эрхлэгчдээс хамгийн их, бага үнэтэй бүтээгдэхүүний талаарх мэдээллийг авахад: Иргэн хамгийн үнэтэй бүтээгдэхүүнээр 200.0 сая төгрөгийн үнэтэй усан болор хөөрөг, мөнгөн эмээл, эмээл, хазаарыг нэрлэжээ. Харин аж ахуйн нэгж 230.0 сая төгрөгийн үнэтэй “Rolex” бугуйн цаг, 200.0 сая төгрөгийн үнэтэй ээмэг, 100.0 сая төгрөгийн үнэтэй мөнгөн эдлэлийг тус тус нэрлэсэн байна.


Судалгаанд хамрагдсан нэгжийн үйлчилгээний талаарх мэдээлэл. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгч 1155 нэгжийн дөнгөж 78 (6.8%) нь интернэт ашиглан захиалга авч, бүтээгдэхүүнээ борлуулдаг байна.

Мөн 1155 нэгжийн 42 (3.6%) хувь нь үйлчлүүлэгчтэй нүүр тулж уулзахгүйгээр бараа бүтээгдэхүүнээ борлуулсан бөгөөд энэ тохиолдолд борлуулсан хамгийн их үнэтэй бүтээгдэхүүн нь 15.0 сая төгрөг, хамгийн бага үнэтэй бүтээгдэхүүн нь 5.0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүн байжээ.

Зураг 6. Нийт харилцагчдын тоо, дунджаар



Харилцагчийн мэдээлэл. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгч нэгжүүдийн 502 (43.5%) нь жилд дунджаар 100 хүртэлх хүнд, 352(30.4%) нь 101-500 хүнд тус тус үйлчилсэн байна.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгч нэгжүүдийн 39(3.4%) нь улс төрд нөлөө бүхий этгээдэд үйлчилгээ үзүүлсэн, 909(78.7%) нь үйлчилгээ үзүүлээгүй, 207 (17.9%) нь мэдэхгүй гэсэн байна.

Улс төрд нөлөө бүхий этгээдэд үзүүлсэн үйлчилгээ. Үйлчилгээ үзүүлсэн 39 нэгжийн 28 (69.2%) нь дунджаар 5 хүртэлх улс төрд нөлөө бүхий этгээдэд үйлчилгээ үзүүлжээ. Улс төрд нөлөө бүхий 3 этгээд 20 саяас дээш төгрөгийн худалдан авалт хийснээс 20.0 саяар 1, 45.0 саяар 1, 60 саяар 1 худалдан авалт тус тус хийсэн байна.

Улс төрд нөлөө бүхий этгээдэд үйлчилгээ үзүүлсэн 39 нэгжийн 16 (41.0%) нь гүйлгээг бэлэн мөнгөөр, 22 (56.4%) дансаар хийсэн байна.

Зураг 7. Гадаад үйлчлүүлэгчид, дүнд эзлэх хувиар

Гадаад иргэнд үзүүлсэн үйлчилгээ. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдаа эрхлэгч 1155 нэгжийн 247 (21.4%) нь гадаадын иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Санхүү, борлуулалтын мэдээлэл. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгч 1155 нэгжийн 142 (12.3%)-д нь үйл ажиллагаа явуулж эхэлснээсээ хойш нэг үйлчлүүлэгч 20 сая ба түүнээс дээш төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээ хийж байсан гэж хариулжээ. Бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн 142 нэгжийн 122 (85.9%) иргэн, 20 (14.1%) нь аж ахуйн нэгж байна.


Хүснэгт 6. 20 сая төгрөг ба түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн нэгжийн тоо

	Бүгд	ААН	Иргэн
Тийм	142	20	122

Үгүй	1013	101	912
Дүн	1155	121	1034

Үйл ажиллагаа явуулж эхэлснээсээ хойш нэг үйлчлүүлэгчид 20 сая ба түүнээс дээш төгрөгийн бэлэн мөнгөний борлуулалт хийж байсан 142 нэгжийг газар зүйн байршлаар авч үзвэл Улаанбаатар хотод 59 (41.5%), Баянхонгор аймагт 24 (16.9%), Сэлэнгэ аймагт 10 (7.0%), Төв аймаг 5 (3.5%), Хэнтий аймаг 5 (3.5%) байрлалтай бөгөөд эдгээр нэгжүүд нь нийт дүнгийн 72.4 хувийг бүрдүүлж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгч 1155 нэгжийн 971 (84.1%) нь жилийн дундаж борлуулалтын орлогын хэмжээг 20 сая хүртэл байдаг гэж хариулжээ. 971 нэгжийн 908 (93.5%) нь иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч байна.



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай ойлголтын талаар. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа, эртний эдлэлийн арилжаа худалдааг эрхлэгч 1155 нэгжийн дөнгөж 63 (5.5%) нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн талаар мэдлэг, ойлголт сайтай, 264 (22.9%) дунд зэргийн, 325 (28.1%) мэдлэг, ойлголт багатай, **503 (43.5%) нь буюу ихэнх нь огт мэдэхгүй** гэсэн хариулт өгсөн байна.

Үндэсний статистикийн хороо

2020-08-13